



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Гэрээт аудитор:	М.Дүүрэнжаргал
		Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.25 № 1-С/191

танай _____ -ны № _____ -т

УЛААНБАДРАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.ХИШИГБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

010020021

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

010020024

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	59.7	56.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,239.6	2,235.8
	Нийт хөрөнгийн дүн	2,299.3	2,292.6
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,299.3	2,292.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,299.3	2,292.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	729.5	611.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	366.6	507.0
	Үйл ажиллагааны үр дүн	362.9	104.0
	Үйл ажиллагааны бус үр дүн	(19.1)	(43.8)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	343.8	60.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	(81.4)	(60.2)
	Эцсийн үлдэгдэл	2,299.3	2,292.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	378.7	370.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	347.1	363.3
	Үйл ажиллагааны ЦМГ	31.6	7.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(31.6)	(7.4)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	332.0	322.5
	Урсгал зардал	332.0	322.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	332.0	322.5
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328.4	317.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3.6	4.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм, төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах үйл ажиллагааг эрхэлнэ. Засаг даргын дэргэдэх тасаг, албад нь Тамгын газраас боловсруулж, Засаг даргын шийдвэрлэсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээнэ. Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллага нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг авсан. 1 албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан боловч, 4 зөвлөмжийг биелүүлээгүй байна. Шилэн дансны системийн бусад хэсэгт аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хэсэгт зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан хэмээн худал тайлан үйлдэж, мэдээлсэн байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 297.3 сая төгрөгийн 14 орлогын гүйлгээ, 19.7 сая төгрөгийн 3 зарлагын гүйлгээ, 19.7 сая төгрөгийн 3 худалдан авалтын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 66.3 сая төгрөгийн 36 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш орлого бүхий гүйлгээнээс 3 гүйлгээг, зарлага бүхий 2 гүйлгээг, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 3 гүйлгээг мэдээлээгүй, нийт 36 тушаал, шийдвэрээс 29 тушаалыг хугацаанд нь байршуулж, 7 тушаалыг байршуулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 794.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 792.8 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

1. Ерөнхий журналыг зардал тус бүрээр шүүн үзэхэд 6.5 сая төгрөгийн 34 гүйлгээг зардлын ангилал буруу тайлагнасан байна. Тус алдааг аудитын явцад залруулав.
2. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс ажиллах жил оруулаагүй хөрөнгийг шүүж үзэхэд 4 дансны 539.9 сая төгрөгийн 1,199 ширхэг хөрөнгө илэрснийг ашиглах жил оруулан, элэгдлийг тооцон аудитын явцад залруулав.
3. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс данс бүрээр шүүхэд 91.1 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг газар дансанд, 155.1 сая төгрөгийн хашааг барилга, байгууламж зэрэг буруу хөрөнгийн дансанд бүртгэсэн хөрөнгийг аудитын явцад залруулав.

Зөвлөмж:

1. Тус байгууллагын санхүү албаны дарга Т.Алтанцэцэгт төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийн дагуу бус шатлалын үндсэн цалингаас нэмүү дүнгээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулсан байна. Т.Алтанцэцэг нь ТЗ-5 шатлалаар буюу 0.8 сая төгрөгийн үндсэн цалинтай боловч Улаанбадрах сумын Засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн Б/09 захирамжаар үндсэн цалинг 0.9 сая төгрөгөөр тогтоосон байна.
2. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч баримтжуулж, баталгаажуулаагүй.
3. Малыг нас дэвшүүлээгүй бөгөөд өмч хамгаалах комиссоос малын зах зээлийн үнийг тогтоогоогүй байна.

Албан шаардлага:

1. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 1 албан шаардлагын биелэлтийг хүргүүлсэн боловч 4 зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байх, үндсэн хөрөнгийн бүртгэлд ашиглах жилийг оруулаагүй байх, Сумын засаг даргын шагналын журам батлах зэрэг зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.2 заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналаас элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг шүүж үзэхэд 5 дансны 269.2 сая төгрөгийн 309 ширхэг хөрөнгө илэрсэн бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.2 заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Мөнгөн гүйлгээний журналаас зардал тус бүрээр шүүн, анхан шатны баримттай тулгахад нормын хувцас, зөөлөн эдлэл зардлын данснаас 0.07 сая төгрөгийн цэвэрлэгээний материал, бичиг хэргийн зардлаас 0.07 сая төгрөгийн принтерийн засвар, тамганы эх боловсруулсны хөлс, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал зардлын данснаас 0.03 сая төгрөгийн бага үнэтэй, түргэн элэгдэх материал болон даатгалын үйлчилгээний төлбөрөөс 0.02 сая төгрөгийн малын албан татвар төлсөн байна. Нийт 4 зардлын данснаас 0.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 *"Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах"*, *Засгийн газрын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*-ыг тус тус зөрчиж, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	9	794.4	3	792.8	-	-	3	0.2	3	1.4
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	9	794.4	3	792.8	-	-	3	0.2	3	1.4